



Дархан-Уул аймгийн Засаг даргын дэргэдэх  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР




**2021 ОНЫ ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН,  
2022 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ**

2022-03-11

---

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР 2021 ОНД **67.5 ТЭРБУМ** ТӨГРӨГИЙН ТӨСӨВТ ӨРТӨГТЭЙ, **76** ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАЛТЫГ ДАВХАРДСАН ТООГООР **148** УДАА ЗАРЛАЖ, 100 ХУВИЙН ГҮЙЦЭТГЭЛТЭЙ **1.6 ТЭРБУМ** ТӨГРӨГИЙН ХЭМНЭЛТ, ҮР АШИГТАЙ, ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ ЗОХИОН БАЙГУУЛСАН.



# 58 ХУВЬ нь ОРОН НУТГИЙН КОМПАНИУД

ГҮЙЦЭТГЭГЧ НЬ ШАЛГАРСАН **71** ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ **41** ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД ОРОН НУТГИЙН КОМПАНИУД ШАЛГАРЧ, **10.5 ТЭРБУМ** ТӨГРӨГИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛСАН БАЙНА.

## 2021 ОНД ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ НАРААС ГАРГАСАН ГОМДЛЫН МЭДЭЭЛЭЛ

№	Төсөл арга хэмжээний нэр /багцын дугаар/	Гомдол гаргасан оролцогчийн нэр	Хаана гомдол гаргасан	Гомдлыг хянасан шийдвэрийн утга	Шийдвэрийг хэрэгжүүлсэн байдал	Тайлбар
1	Гудамж, зам талбайн гэрэлтүүлэг /Дархан сум, 9, 10, 11, 12-р баг/	"ЛэдСити" ХХК	Сангийн яам	Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй	Шалгарсан "Ингүүмэл эрчим" ХХК-тай гэрээ байгуулсан	
2	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам /Дархан-Уул, Дархан сум, 1, 2, 8 дугаар баг/	"Цахимбар инженеринг" ХХК	Сангийн яам	Дахин үнэлгээ хийх	ТБОНӨХБАҮХАТХ-ийн 55 дугаар зүйлийн 55.3.1 дэх заалтын дагуу Үнэлгээний хороо дахин үнэлгээ хийж "ОДНД" ХХК-тай гэрээ байгуулсан.	
3	Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай авто зам /Дархан-Уул, Шарын гол сум/, Багц 1	"Анандын зам" ХХК	Сангийн яам	Дахин үнэлгээ хийх	ТБОНӨХБАҮХАТХ-ийн 55 дугаар зүйлийн 55.3.1 дэх заалтын дагуу Үнэлгээний хороо дахин үнэлгээ хийж хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д заасны дагуу шаардлага хангасан нэг ч оролцогч ирээгүй тул бүх тендерээс татгалзсан.	Дахин тендер зарласан.
4	Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай авто зам /Дархан-Уул, Шарын гол сум/, Багц 2	"Өсөх Урам" ХХК	Сангийн яам	Дахин үнэлгээ хийх	ТБОНӨХБАҮХАТХ-ийн 55 дугаар зүйлийн 55.3.1 дэх заалтын дагуу Үнэлгээний хороо дахин үнэлгээ хийж хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д заасны дагуу шаардлага хангасан нэг ч оролцогч ирээгүй тул бүх тендерээс татгалзсан.	Захиалагч бүх тендерээс татгалзаж, дахин зарласан боловч "Өсөх Урам" ХХК шүүхэд гомдол гаргасан. Шүүхийн шийдвэрээр /2022.02.10/ нэхэмжлэхийг хэрэгсэхгүй болгосон.
5	Хуучин хөлбөмбөгийн талбайг түшиглэн орчин үеийн хөлбөмбөгийн талбай байгуулах /Дархан-Уул, Шарын гол сум/	"ЭйчБиЭс" ХХК	Сангийн яам	Дахин үнэлгээ хийх	ТБОНӨХБАҮХАТХ-ийн 55 дугаар зүйлийн 55.3.1 дэх заалтын дагуу Үнэлгээний хороо дахин үнэлгээ хийж хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д заасны дагуу шаардлага хангасан нэг ч оролцогч ирээгүй тул бүх тендерээс татгалзсан.	Дахин тендер зарласан.
6	Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай авто зам /Дархан-Уул, Шарын гол сум/, Багц 1	"Таны зам" ХХК	Сангийн яам	Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй	Шалгарсан "Анандын зам" ХХК-тай гэрээ байгуулсан	


# Үнэлгээний хороо

Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй хариуцлагатай байх зарчмыг баримтлах, авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл бүрдүүлэхгүй байхад анхаарч, иргэд, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллөөс Үнэлгээний хороонд давхардсан тоогоор 150 гаруй иргэдийг оролцуулж, хөндлөнгийн хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэн ажилласан. Үнэлгээний хороонд хөндлөнгийн хяналтаар оролцсон иргэд, төрийн бус байгууллагын 50 иргэнд 3,574.8 мянган төгрөгийн урамшуулал олгож ажилласан.

Худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн албан хаагчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн суурь мэдлэг олгох сургалтыг төрийн бус байгууллагатай хамтран 2021 онд 3 удаа зохион байгуулж 160 хүн хамруулхад, 68 хүн тэнцсэн.


# 2022 ОНЫ ХУДАЛДАН АВАЛТЫН ЯВЦЫН ТАЙЛАН

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 32 байгууллагын 21.6 тэрбум төгрөгийн 508 төсөл арга хэмжээг цахим системээр нэгтгэн баталгаажуулж, Сангийн яаманд илгээж, Худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системд ил тод, нээлттэй мэдээлсэн.




**ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН 162.7 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ТӨСӨВТ ӨРТӨГТЭЙ, 64 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА.**

Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль, Монгол Улсын Засгийн Газрын 359, 61 дүгээр тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 115.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 28, шилжих хөрөнгө оруулалтаар хэрэгжих 35.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл арга хэмжээ тус тус эрх шилжигдэн ирсэн.






## ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ ХЭРЭГЛЭСЭН БАЙДАЛ;



# ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ БУЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЯВЦ 69%

2022.03.10-ны өдрийн байдлаар



	УТ	ОНТ	ОНХС	Авто замын сан	БОХНСАХЗ
■ Зарлагдсан	27	3	2		1
■ Үнэлгээний шатанд					
■ Дахин зарлагдах	1	2			
■ Гэрээ байгуулагдсан	3	4		1	
■ ТББ боловсруулах					
■ ТЭЗҮ ирээгүй		14	4		2



## ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

- Захиалагч Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг цахим системээр дамжуулан Сангийн яаманд тайлагнана.
- Тендерт оролцогч цахим системээр тендерийн баримт бичгээ татаж авах, тендер илгээх, тендер шалгаруулалтын үр дүнг харах, гомдол гаргах, гэрээ баталгаажуулж, гүйцэтгэлээ оруулна.
- Төрийн байгууллагуудаас гарч байгаа лавлагаа, мэдээллийг тендерт оролцогчоос шаардахгүй, цахим системээр дамжуулан авах боломжтой болсон.

# ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМ НЬ ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ “ХУР” СИСТЕМЭЭР ДАМЖУУЛАН ДООРХИ БАЙГУУЛЛАГУУДААС МЭДЭЭЛЭЛ АВЧ БАЙНА

## САНГИЙН ЯАМ

Санхүүгийн тайлангийн мэдээлэл

## УЛСЫН БҮТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Хуулийн этгээдийн ерөнхий мэдээлэл

## АВТО ТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээлэл

## ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН ГАЗАР

Худалдан авах ажиллагаанд оролцохдоо шүүхэд хариуцагчаар татагдсан эсэх мэдээлэл

## ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

Татварын өр төлбөрийн талаарх тодорхойлолт

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

Нийгмийн даатгалын өр, төлбөрийн талаарх тодорхойлолт

## АРИЛЖААНЫ БАНКУУД

Цахим тендерийн баталгаа

## БШУЯ

Мэргэжлийн дипломын мэдээлэл

# Мэдээллийн ил тод байдал

Төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим систем, Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны [www.darkhan.gov.mn](http://www.darkhan.gov.mn), газрын [www.darkhanumch.com](http://www.darkhanumch.com) мэдээллийн цахим хуудаст худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр байршуулж, үндэсний хэмжээний өдөр тутмын “Өглөөний сонин” хэвлэлийн газартай гэрээ хийж хамтран ажиллаж байна.

Шилэн [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) дансанд худалдан авах ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүн, худалдан авалтын талаарх ерөнхий мэдээллийг тухай бүр байршуулж ажилласан.

Үнэлгээний хорооны гишүүдийг “RANDOM” ашиглан томилж байна. Өнөөдрийн байдлаар Үнэлгээний хороонд ажиллах АЗ сертификат эзэмшигч 203 хүн бүртгэлтэй байна. Үүнээс:

- Удирдах албан тушаалтан: 22
- Төрийн албан хаагч: 45
- Төрийн бус байгууллагын төлөөлөл: 4
- Иргэний төлөөлөл: 132

---

# АНХААРАХ АСУУДЛУУД:

- Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд **ГЭРЭЭ ШУУД БАЙГУУЛАХ** арга байхгүй болсон, тиймээс худалдан авалт зөвхөн тендерээр зохион байгуулагдана.
  - Материалын үнэ өссөнтэй холбоотойгоор тендерт оролцогч ирэхгүй байна.
  - Цаг үеийн нөхцөл байдал хил, гааль, тээвэр зэрэг хүчин зүйлсийн эрсдэлийг тооцон бодит судалгаанд тулгуурлан төлөвлөлт хийх шаардлагатай байна.
  - Үнэлгээний хорооны даргаар ажиллах агентлаг, хэлтсийн дарга нарын тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.
  - Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал харьяа нутаг дэвсгэр дэх захиалагчийн тендер шалгаруулалтын үнэлгээний хороонд ажиллах иргэний жагсаалтыг тогтмол хөтөлж, өөрийн цахим хуудсаар олон нийтэд нээлттэй мэдээллэх
-

**АНХААРАЛ ХАНДУУЛСАНД  
БАЯРЛАЛАА**